



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Г Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, Т
удирдамж батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчтөй болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Аминдаваагийн Молорыг томилсугай.

2.“Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч А.Молорт даалгасугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 сарын 03.-ны өдрийн
163 дугаар тогтоолын хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ ТУЛШ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ
ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Ногдол ашиг хуваарилахгүй талаар гарсан шийдвэр нь Компанийн тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас гарсан тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж буй эсэхэд үнэлэлт өгч, Компанийн санхүүгийн болон нийгмийн өгөөжийн үзүүлэлтийг сайжруулах талаарх үүрэг чиглэлийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад өгөх;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцан, тус асуудалтай холбогдуулан гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд үнэлэлт өгч батлан, цаашид Компанийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн байдлаар саналаа өгч оролцох;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг чиглэл өгөх;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтооолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”, Засгийн газрын 2024 оны 85 дугаар тогтооолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу томилох;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөвтэй танилцан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, саналаа тусгаж оролцох;
6. Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрмийн холбогдох зүйл заалтыг баримтлан “Тавантолгой тулш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалд санал өгч оролцох;
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг зарласнаас хойш зайлшгүй хэлэлцэх нэмэлт асуудал гарсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар дэмжигдэх эсэхийг харгалзан, дэмжигдсэн тохиолдолд нэмэлтээр хэлэлцүүлэхээр оруулж ирсэн асуудлыг Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон хэлэлцэх асуудалтай холбоотой бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн саналаа өгч оролцох.